


**Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн 2020 оны жилийн эцсийн
статистикийн тайлан
/2020.01.01-11.30 хүртэлх/**

АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Амбулаторийн үзлэг 312,918 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,4% (n=4414)-аар өссөн байна.




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад :

Амбулаторит анхан үзлэг 2,3% (n=4798), урьдчилан сэргийлэх үзлэг 27,7% (n=4199)-аар буурсан бол давтан үзлэг 17% (n=13411)-аар өссөн байна.

АМБУЛАТОРИЙН ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ

Амбулаторийн халдварт бус өвчлөл 125,936 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 0,8% (n=1053)-аар өссөн байна.




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад :

Шинэ өвчлөл нь 7,3% (n=9084)-аар буурсан бол хуучин өвчлөл 18% (n=10,137)-аар өссөн байна.

ОСОЛ ГЭМТЭЛ

2020 онд осол гэмтлийн шалтгаант 494 өвчлөл бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50,4% (n=172) нэмэгдсэн байна.

Осол гэмтлийн өвчлөлийг төрлөөр харуулбал:




- ✓ Бүх төрлийн хорлого - 362
- ✓ Хүнд зодуулсан - 37
- ✓ Амьгүй механик хүчинд өртөх – 30
- ✓ Бүх төрлийн уналт – 29
- ✓ Амиа хорлохыг завдах - 24
- ✓ Зам тээврийн осол – 6
- ✓ Мал амьтанд мөргүүлэх, хөшиглүүлэх – 4

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл нь өмнөх онтой харьцуулахад 50,4%-аар өссөн байгаа нь COVID-19 өвчний улмаас цэргийн төв эмнэлгийн хордлогийн шалтгаант өвчлөлийг авдаг болсон. Мөн 2020.11 сараас СБД-ийн осол гэмтлийн шалтгаант өвчлөлийг авдаг болсонтой холбоотой.

СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2020 онд стационарт 20,447 хэвтэн эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж урьд оны мөн үеийнхээс 12,7% (n=2,968)-аар буурсан байна.


Стацинорит хэвтэн эмчлүүлсэн хүн болон ор хоног:



Нийт ашигласан ор хоног 124,110 бөгөөд дундаж ор хоног 6, орны эргэлт 41,9 байна

МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ онд нийт 12,404 мэс засал орж өмнөх оноос 4,6% (n=543)-аар өссөн байна.




Төлөвлөгөөт мэс засал 0.8% (n=74) буурсан бол яаралтай мэс засал 20% (n=617), дурангийн мэс засал 1,6% (n=60)-аар тус тус өссөн байна.

НАС БАРАЛТ


Энэ онд нас баралтын 356 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 12% (n=43) нь эмнэлэгт хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Урьд онтой харьцуулвал нас баралт 22 тохиолдол, хоног болоогүй нас баралт 17 тохиолдлоор тус тус буурсан байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт 2,8% (n=10)-ийг эзэлж байгаа бөгөөд 9 тохиолдол нь архины шалтгаант нас баралт байна.



Нас баралтын бүтцийг авч үзвэл:



Нас баралтын өвчлөлийн бүтцээр авч үзвэл ХБЭ 28,7% (n=102), хавдар 15,2% (n=54), АЗЭ 14% (n=50), цус харвалт 11% (n=39), ЗСЭ 7% (n=25)-ийг тус тус эзэлж байна.